

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИЙН 2026 ОНЫ  
ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2026.06.15

№	Стратегийн чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжилтийн явц , үр нөлөө	Өөрийн үнэлгээ
1.	Андрагоги ба заах арга зүй	1."Амьдрах ухааны жишиг хөтөлбөр" (А/577) дагуу насанд хүрэгчдийн сэтгэл зүйн онцлог, хэрэгцээг тодорхойлох сургалт зохион байгуулах 2."Flipped classroom" болон кэйс шинжилгээний арга зүйг нэвтрүүлэх практик воркшоп	1.Боловсролын сайдын 2025 оны А/577 дугаар тушаалаар батлагдсан “Хувь хүний хөгжлийг дэмжих амьдрах ухааны сургалтын жишиг хөтөлбөр-т нийцүүлэн 7 багш насанд хүрэгчдийн хэрэгцээ, тэдэнд хүргэх арга зүйгээ тодорхойлон 14 багц хичээл бэлтгэж баглуулсан. 2.Юнеско-гийн Насанд хүрэгчдийн боловсролын хүрээлэнгийн сургалтад энэ чиглэлийн арга зүйд 10 багш, ажилтан хамрагдаж сертификат авсан. <b>Үр дүн: Багш нар жишиг хөтөлбөрийн модулиар хичээл бэлтгэж, сургалтдаа ашиглаж байна.</b>	80%
2.	Дижитал шилжилт ба AI технологи	1.МХХТ-ийн чадамжийн хүрээнд (А/57) Google Classroom болон LMS ашиглах дунд шатны сургалт зохион байгуулах 2.Сургалтын хэрэглэгдэхүүн, хөтөлбөр бэлтгэхэд AI (хиймэл оюун) хэрэгслүүдийг ёс зүйтэй ашиглаж сурах дадлагажих 3.Canva болон видео хэрэгслүүд ашиглан интерактив контент бүтээх	1.Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын 2024 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан МХХТ-ийн Боловсролын сургалтын жишиг хөтөлбөрийн Google Classroom болон LMS ашиглах дунд шатны сургалт 2027 оноос эхэлнэ. 2.AI (хиймэл оюун) хэрэгслүүдийг ёс зүйтэй ашиглаж сурах дадлагажих сургалтад 6 багш, 6 менежер суралцсан. Дүүргийн иргэдэд зориулан “Цахим үйлчилгээ авах”, “цахим орчинд хувийн мэдээллээ аюулгүй түвшинд ашиглах, хуваалцах”, “баталгаат нууц үг ашиглах” энэ бүгдэд хиймэл оюуныг хэрхэн ашиглах 112 удаагийн сургалтад 1220 иргэнийг хамруулсан. 3. Canva болон видео хэрэгслүүд ашиглан интерактив хичээл бэлтгэх сургалтад 6 багш хамрагдсан.Иргэдэд “цахим орчинд ярих, видео дуудлага хийх, цахим орчноос үнэн зөв мэдээлэл авах” зэрэг ур чадварыг нөлөөллийн ажлаар дамжуулан 15000 гаруй хүнд хүргэсэн байна. <b>Үр дүн:Насанд хүрэгчдийн нийгэм болон цахим орчинд дасан зохицох, өсөн хөгжих, бие даан суралцахад дэмжлэг үзүүлсэн.</b>	90%

3.	Орон нутгийн сурах хэрэгцээг тодорхойлох, датад суурилсан "Судлаач-багш" чадавхыг бэхжүүлэх	<p>1.Орон нутгийн иргэдийн сурах хэрэгцээний судалгаа авах, дата мэдээллийг (Excel/Google Sheets) ашиглан нэгтгэх, графикжуулах сургалт</p> <p>2.Багш нарыг цахим орчинд мэдээллийн үнэн зөв байдлыг шүүн тунгаах, мэдээллийн дархлааг иргэдэд төлөвшүүлэх чиглэлээр бэлтгэх</p> <p>3.Багш нар мэргэжлийн бүлэг хамрагдах багшийн мэргэжил дээшлүүлэх 1, 5, 10 жилийн үндсэн сургалтад хамрагдах</p>	<p>1.Дүүргийн 34 хорооны иргэд, байгууллага хамт олноос сурах хэрэгцээний судалгаанд 5000 хүн хамруулсан. Иргэдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн мэдээллийн технологи, хувь хүний хөгжил, оёдол эсгүүр, ТХБ-ын 715 удаагийн сургалтад 10225 хүн хамруулсан.</p> <p>2.Төвийн 6 багш 6 менежер Дижитал бичиг үсэг насанд хүрэгчдийг сургах арга зүй сургалтад 1-2 удаа хамрагдаж батламж авсан.</p> <p>3. 1 жилийн сургалтад 2 багш хамрагдсан, 2026 оны 5,10 жилд хамрагдах багш байхгүй.</p> <p><b><i>Үр дүн:Багш нар өөрийгөө хөгжүүлэх болон мэргэжлийн сургалтад тогтмол хамрагдаж сертификатаар баталгаажуулж нотлох баримттай ажиллах аргад суралцсан</i></b></p>	100%
4.	Ажлын байрны сэтгэл зүйг дэмжих, эерэг соёлыг төлөвшүүлэх чиглэл	<p>1 Багш, ажилтнуудын ажлаас халшрах буюу ажлын байрны стрессээс сэргийлэх, сэтгэл зүйг өргөх, сайн туршлага дэлгэрүүлэх замаар дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх.</p> <p>2 Төрийн үйлчилгээний соёл, сахилга хариуцлага, багаар ажиллах чадвар, багшийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, үе тэнгийн дээрэлхэлт, эрсдэлээс сэргийлэх нөлөөлөл үзүүлж сургалтын болон цагийн менежментийг үр дүнтэй зохион байгуулах, хувийн бүтээмжийг өсгөх</p>	<p>1. Албан тушаалын шалгуур, шаардлага хангасан 26 албан хаагчидтай. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар албан хаагчдыг дэмжих, урамшуулах, хоол, унааны мөнгө олгох, ар гэрийн аливаа үйлд чөлөө олгох, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах зэрэг уян хатан хүний эрх дээдэлсэн зүйл заалт үйлчилдэг. 2.2025 оны 3 сайдын хамтарсан /А/136, А/80, А/69/ тушаалыг үндэслэн шалгуур үзүүлэлтийн дагуу албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, ажлын үр дүнгээр сар бүр цалингийн санд багтаан урамшуулал олгодог. Сургалтын хэрэглэгдэхүүнээр байгууллага 100% хангадаг.</p> <p><b><i>Үр дүн: Хамт олон 2025, 2026 онуудад санхүүгийн хувьд өр авлагагүй, ёс зүйн зөрчилгүй, эрсдэлгүй ажиллаж ирсэн.</i></b></p>	100%
5.	"Суралцагч хог Баянгол" загварын хүрээнд олон нийтийн оролцоо, гадаад түншлэлийг өргөжүүлэх чиглэл	<p>1 Зорилтот бүлгүүд, ялангуяа ахмад настан, залуучууд, суралцах боломж хязгаарлагдмал иргэдийг Ахмад настны тухай хууль болон бусад бодлогын удирдамжийн дагуу насан туршийн суралцахуйн үйлчилгээнд хамруулах, нөлөөллийн ажил хийж,</p>	<p>1. Арга хэмээ, үйл ажилагааг удирдамжийн дагуу явуулж илтгэх хуудсаар танилцуулсан. Дүүргийн ахмадын хороотой хамтран Эрүүл мэнд- идэвхтэй хөдөлгөөн аян, ЗДТГ спорт хорооны Ажлын байрны дасгал хөдөлгөөн аян, Сурахын баяр арга хэмжээ, Дүүргийн залуусын цэрэг татлага зэрэг ажил үйлчилгээнд оролцож тайлагнадаг. Эдгээр ажлуудаар</p>	90%

		<p>дүүргийн хэмжээнд "Суралцагч хот"-ны соёлыг бүрдүүлэх</p> <p>2 Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын төсөл (ЮНЕСКО-гийн GNLC), хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй "Ногоон боловсрол"-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх</p> <p>3 Суралцагчдад карьер чиг баримжаа олгох, суралцах сэдэл үүсгэх зөвлөгөө, чиглүүлэг (mentoring) хийх арга зүйг эзэмшүүлэх</p>	<p>дамжуулан "Суралцагч хот"-ны соёлыг түгээн дэлгэрүүлэн ажилласан.</p> <p>2. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж 120 байгууллагатай уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй "Ногоон боловсрол"-ын хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.</p> <p>3. Байгууллага дотоод сургалтыг 7 хоногийн 5 дахь өдөр бүр хуваарийн дагуу зохион байгуулдаг. Сургалтаар иргэд рүү гарах сургалт, нөлөөллийн ажлаа “үзүүлэх хичээл” болгон зааж санал солилцон зөвлөн тусалж, харилцан суралцах, арга зүйгээ хуваалцдаг. Залуусаас мэдээллийн технологийн шинэ шийдэл, ахмадууд туршлага түгээсэн, чиглүүлсэн үйл явц өрнөдөг.</p> <p><i>Үр дүн: Сургалт, зөвлөгөөн нь залуусыг карьер баримжаатай болох, дунд ахмад үе залуусаас суралцах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх арга зүйг хэвшүүлэх боломж бүрддэг.</i></p>	
--	--	---	--	--

ТАЙЛАН БИЧСЭН:  
МЕНЕЖЕР Б.БАЯРСАЙХАН  
БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН Н.АЛТАНЦЭЦЭГ

**Байгууллагын албан ёсны хаяг:**

**Хаяг байршил:** Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18-р хороо

**Холбоо барих утас:** (976) 7707-0110

**Цахим шуудан:** bgd-llc@agency.edu.mn